

АЙМГИЙН НАМЫН XVI БАГА ХУРАЛД БАЯР ХҮРГЭЭ!

Орон бүхний, пролетариат нар нэгдэгч! АНХ ДЭГТАЙР ТАВАН ЖИЛ

Төв аймгийн Намын Хороо, А.Д.Х-ын гүйцэтгэх захиргааны сонин

27 дахь жилдээ № 47 (2311) 1974 оны 6 дугаар сарын 21 ПҮРЭВ

АЙМГИЙН НАМЫН XVI БАГА ХУРАЛ

Оноодор, аймгийн Намын ээлжит XVI бага хурал нээгдэж байна. Тус бага хурал, МАХН-ын III их хурал хуралдааны болон БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн ой угтаа бүх ард түмний социалист уралдаан орноос, МАХН-ын Төв Хорооны VIII бүгд хурал, БНМАУ-ын Ардын Их Хурлын нийм дахь удаагийн сонгуулийн III чуулганы шийдвэрийг хүлээн авч байгаа үед тохиолдож байна.

МАХН өөрийн програм, XVI их хурлын шийдвэрт дэвшигдсэн дотоод, гадаад улс төрийн жэргэн зон бодлогоо хэрэгжүүлж, ЗСБНХУ болон социалист ноёрхолтийн орнуудтай тогтоосон найрамдал хамтын ажиллагаагаа бэхжүүлж, манай социалист байгуулалтын хөгжил, ард түмний аж байдал, соёлын хэмжээ байнга дээшилж байгааг тус аймгийн коммунистууд нийт хөдөлмөрчид сайнаар байна.

Сүүлийн 3 жил гаруй хугацаанд аймгийн намын байгууллага, хөдөлмөрчдөөс МАХН-ын XVI их хурлын түүхэн шийдвэр, V таван жилийн төлөвлөгөөг зорилтыг биелүүлэх талаар өрнүүлсэн ажлын дүнг энэ бага хурал гаргаж, аймгийн Намын хороог сонгон, цаашд зорилтыг тодорхойлно.

Манай аймгийн хөдөлмөрчид өрнүүлн хөдөлмөрийнхээ үрээр таван жилийн төлөвлөгөөний эхний гурван жилд 80 гаруй мянган мал нэмэгдүүлэн, түүхэн хөгжлийнхөө 50 жилд хураагаагүй ондор ургац хурааж Засгийн газрын хүндэт жуух бичгээр шагнагдлаа. ЗХУ-ын өгөөмөр их тусламжаар саалийн иж бүрэн хэд хэдэн ферм үүрэн, агуулахууд баригдаж хөдөө нутгийн нүүр царай минжээлэгдэн, аймгийн хэтийн хөгжлийн яруу сайхан төлөв нээгдэв.

Үйлдвэр, аж ахуй, ардын боловсрол, соёлын байгууллагууд таван жилийн төлөвлөгөөний зорилтыг амжилттай хэрэгжүүлж байна. Намаас явуулсан сурган хүмүүжүүлэх ажлын ачтай сайхан дотооны дор манай үеийн шинэ хүмүүс төлөвшил энэ хугацаанд тус аймгаас БНМАУ-ын хөдөлмөрийн баатар 8, гавьяат уурхайчин, хуульч, эмч, багш, худалдааны ажилтан, дэд эрдэмтэн тус бүр нийгээд төрөн гарав.

Намын анхан шатны байгууллагууданс явуулах үзэл суртал зохион байгуулалтын ажил сайжирч, хөдөлмөрийн хамт олон дайчин мандайлагчийн үүргээ амжилттай биелүүлж байна.

Аймгийн намын ээлжит бага хуралд 2200 гаруй гишүүд, орлогч гишүүдийг төлөөлсөн 100 шахам төлөөлөгч сонгогдсоны дотор Жаргалантын САА-н трактор-комбайнч, БНМАУ-ын хөдөлмөрийн баатар Ч.Дугарсүрэн, Эрдэнэсант сумын "Саруул амьдрал" нэгдлийн хоньчин, улсын аварга малчин Н.Базаррагчаа, Угтаадын САА-н дарга Б.Батчулуун нарын зэрэг манай үеийн ажилчин, малчин, сэхээтний шилдэг төлөөлөгчид оролцож байна. Олон амжилтаа бахархан дүгнэхийн зэрэгцээгээр өмнөө зогсож байгаа зорилтыг хэзээ яаж хэрэгжүүлэхээ төлөвлөн тогтоодог явдал манай намын ажил амьдралын хөдөлмөрийн зарчим юм.

Ийм учраас аймгийн намын байгууллагын ажлыг тал бүрээс нь дүгнэн үзэж, амжилт оршиж байгаа дутагдал түүний шалтгааныг илрүүлэн шүүмжилж, цаашдын зорилтыг шийдвэрлэх арга замыг захад бага хурлын гол зорилт оршино. "Сайхан хуралдаан МАХН-ын Төв Хорооны VIII бүгд хурлын шийдвэр, зун, намар малыг бэлчээрээр таргалуулах, бүх төрлийн малын нийлүүллийг сайн бэлтгэлтэй хийх, тэжээл бэлтгэх төлөвлөгөөг бүрэн биелүүлэх, мал оволжүүлэхэд бэлтгэх, ур тариа, малын тэжээл, хүнсний ногооны тариаланг нийт илжбай арчлан, ургац хураах амжилд бэлтгэх, ХАА-н бүтээгдэхүүн бэлтгэх төлөвлөгөөг биелүүлэх явдал оноодрийн тулгамдсан зорилт мөн. Бага хурлынхаа шийдвэрийн дагуу ооредийн ажилдаа тодорхой дүгнэлт хийж, ажлынхаа эрч дайлагыг улам нэмэгдүүлэх явдал тус аймгийн нам, улс, олон нийтийн байгууллагуудын чухал зорилт болж байна.

БҮГД ХУРАЛ, ЧУУЛГАНЫ ШИЙДВЭР АМЬДРАЛД

МАХН-ын Төв Хорооны VIII бүгд хурал, Ардын Их Хурлын 8 дахь удаагийн сонгуулийн III чуулганы шийдвэрийг хүлээн авах хөдөлмөрдийн хурлууд Зуунмод хотын үйлдвэр, аж ахуй, соёлын байгууллагуудад болов.

МАХН-ын Төв Хорооны гишүүн, аймгийн Намын хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга Ц.Адъяа, АДХ-ын гүйцэтгэх захиргааны дарга Ч.Дашдэмбэрэл нар Зуунмод хотын АДХ-ын чуулганы танхим, Соёлын ордонд болсон хөдөлмөрдийн хурал дээр бүгд хурал, чуулганы талаар дэлгэрэнгүй мэдээлэл хийж бүгд хурал, чуулганы шийдвэрийг амьдралд хэрэгжүүлэх асуудлаар тодорхой ярих.

НААУ-ний газар, Барилга контор, Тээврийг удирдах газар, ЭХ газар, Нэгдэл дундын үйлдвэр зэрэг газруудад болсон хөдөл-

Эдийн засгийг хөгжүүлэх, намын эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэх явдал манай ажлын гол фронт мөн. Аж ахуйн байгуулалтыг намаас удирдах ажлын хэмжээг улам дээшлүүлэхэд манай зорилт оршиж байна.

МАХН-ын Төв Хорооны VIII бүгд хурал дээр нөхөр Ю.Цэдэнбалын хэлсэн үгнээс

НАМЫН БАГА ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧ



Батсүлбарийн САА-н саальчин, БНМАУ-ын хөдөлмөрийн баатар, МАХН-ын гишүүн А.Авирмэд



Жаргалантын САА-н трактор-комбайнч, БНМАУ-ын хөдөлмөрийн баатар МАХН-ын гишүүн Ч.Дугарсүрэн



Алтабулаг сумын "Хөдөлмөр" нэгдлийн тэргүүний саальчин, МАХН-ын гишүүн Д.Чинбат



Аймгийн Хүнсний комбинатын ажилчин, МАХН-ын гишүүн Б.Төмөрдулам

АМЖИЛТ ИЛТГЭСЭН РАПОРТ

Аймгийн Намын XVI бага хурал угтаж өрнүүлсэн амжилт бүтээлээ илтгэсэн рапортуудаа тус аймгийн ажилчин, малчин, хамт олон, байгууллагууд прүүсээр байна. Уг рапортын заримыг тоймлон нийтлэв.

● СХ-ийн Зам ангийн хамт олон аймгийн намын XVI бага хурал угтаж 45 хоногийн өндөр бүтээлийн ажил зохиож Лүн сумын 150 метр гүүрийн засварыг дуусгаад 5 цэгт төмөр бетон хоолой шинээр тавьж, Тэрэлжийн замын өргөтгөлийн ажилд зориулж 1000 куб метр чулуу бэлтгэснийхээ 50 хувийг нь тээвэрлэн эхний хагас жилийн төлөвлөгөөг 15 хоногийн өмнө 135,0 хувь биелүүлжээ.

● Ойн аж ахуйнхан энэ оны эхний хагас жилийн үйлдвэрлэлийн нийт бүтээгдэхүүний төлөвлөгөөг 15 хоногийн өмнө 101,4 хувь биелүүлж 24,0 мянган төгрөгийн бүтээгдэхүүн илүү үйлдвэрлэн гуалин бэлтгэлт, таталтыг 100,8—117,3 хувь, гэрийн тооно, унь, багана хийх болон бусад зүйлийн төлөвлөгөөг 101,2—215,0 ху-

виар давуулан биелүүлсэн байна.

● Баяндэлгэр сумаас ирсэн рапортонд дурдахдаа тус сум-нэгдэл бага хурал угтаж хөөвөр, хялгасны төлөвлөгөөг биелүүлэх 5 хоногийн зохистой ажил зохиож төлөвлөгөөг 100,2—102,6 хувиар биелүүлжээ гэжээ.

● Мөн аймгийн Холбооны газар, тээврийн байгууллагын хамт олон сайхан амжилт гаргажээ. Холбооны газар хатас жилийн орлого, бичиг, захидал илгээлт, сумдын яриа, радио, телефон цэг, шуудангийн хайрцаг, пахилгаан мэдээ, телевизийн төлөвлөгөөг 101,4—108,1, тээврийн байгууллагынхан ачаа, хүн эргэлт, хангамжийн таталт борлолтыг 20—30 хоногийн өмнө 100,5—103 хувь биелүүлсэн зэрэг амжилтаар бага хуралдаа бэлэг барилла.

З БАЯРБАТ

ХОЁР БАГА ХУРЛЫН ХООРОНД

Аймгийн намын XV бага хурлаас хойших хугацаанд МАХН-ын XVI их хурлын шийдвэрийг биелүүлэх үйлсэт тус аймгийн хөдөлмөрчид их амжилт олов.

Яруу алдарт малчдын шаргуу хөдөлмөрийн үр дүнд аймгийн хэмжээгээр 3 жилийн нийлбэр дүнгээр 1 сая 300 мянга шахам төл бойжуулан 778 хашаа барьж, 361 худаг гаргаж, эмчилгээ тэжээлийн 18 цэг байгуулж 277,1 мянган тонн төрөл бүрийн тэжээл бэлтгэв.

Баянцогт, Батсүмбэр, Борнуурын САА-нуудад тус бүр 400 үнээний саалийн механикжсан фермүүдийг барьж ашиглалтанд өгөв.

ХАА-д 1971—1973 онд улсаас 103,3 сая төгрөгийн хөрөнгө оруулж нам, засгаас ХАА-н нэгдлийн бэлтгэлийн зүйлийн үнийг нэмж, шагналт үнэ тогтоож хашааны болон богино хугацааны зээлийг хөнгөлөн дотуур байр, яслы цэцэрлэгийн зардлыг улсаас хариуцах болсноор ХАА-н нэгдлүүд 14 сая гаруй төгрөгийн нэмэгдэл орлого оллоо. Үүний үр дүнд ХАА-н нэгдлийн санхүү эдийн засгийн үр дүн сайжран мөнгөн орлого нь 10,7 хувиар өсөв.

Тариаланчид арвин ургац хурааж улсдаа 59,0 мянган ачааны машинд ачи-хаар хэмжээтэй арвин их ургац тушаав.

Аймгийн хэмжээгээр 15 моринь хүчинд шилжүүлснээр тракторын тоо 2070 болж нэмэгдэн, нэг САА, ТАА-д 210, ХАА-н нэгдэлд дунджаар 32 трактор оногдож байна.

Үйлдвэр аж ахуйн газрууд V таван жилийн төлөвлөгөөний эхний 3 жилийн төлөвлөгөөг амжилттай биелүүлж 38,5 сая төгрөгийн бүтээгдэхүүн

үйлдвэрлэн гаргаснаар өмнөх таван жилийн мөн үеийнхээс ашиг 13,0-660,0 мянган төгрөгөөр нэмэгджээ. Хүнсний үйлдвэр, «Анхдугаар таван жил» сонинны СХ-ийн хэвлэх үйлдвэр, Зам ашиглалтын анги аж ахуй, соёлын төлөвлөгөөт үзүүлэлтээр тэргүүлж явна.

Барилга угсралтын контор 920 хүүхдийн сургуулийн барилга, 120 ортой больниц, мал эмнэлэг-ариун цэврийн станц, АД Х-ын гүйцэтгэх захиргааны контор, 24 айлын орон сууц зэрэг олон арван барилга байшин барьж ашиглалтанд орууллаа.

Аймгийн авто тээвэрт саятны бригад, худалдаа үйлчилгээнд хамтын тооцоотой бригад, ардын боловсролын байгууллагад сургалтын шинэ систем зэрэг тэргүүн туршлага нэвтэрснээр эдгээр байгууллагуудын төлөвлөгөөт зорилтууд амжилттай биелэгдэж, хүүхдийн сурлагын чанар сайжирч байна.

Эрүүлийг хамгаалах, харицгаа холбоо, соёл урлагийн байгууллагууд эх ор-

ныхоо социалист бүтээн байгуулалтанд ихээхэн хувь нэмэр орууллаа. Ард түмний аж байдал, соёлын хэмжээ улам бүр дээшилж, аймгийн төв, хөдөөд шинэ шинэ байшин барилгууд баригдан тэдгээрийн нүүр царай өөрчлөгдөн өдрөөс өдөрт жавхаажиг байна.

Өнгөрсөн хугацаанд олсон эдгээр амжилтууд нь аж ахуй, соёлын төлөвлөгөөт зорилтыг шийдвэрлэхэд намын байгууллагууд улам илүү идэвхтэй нөлөөлж дэвшил хөгжлийг түргэтгэхэд шалтгаалах гол хүч бололцоо нь болохыг үйл явдал харууллаа.

Намын байгууллагын байршил бүрэлдэхүүнд чанарын өөрчлөлт гарч өнгөрсөн 3 жилд тэргүүний ажилчин, хоршоолсон малчид, хөдөлмөрийн сэхээтэн 250 гаруй хүнээр намын эгнээг өргөтгөсний дотор 40 гаруй хувийг ажилчин, малчин хүмүүс эзэлж байна.

V таван жилийн төлөвлөгөө амжилттай биелүүлэх их бүтээлийн манлайд коммунистууд явж байна.

Г. ЖАЛБАА

ЗАСВАР ДУУСЛАА

Заамар сумын 8 жилийн дунд сургуулийн захиргаа аймгийн намын XVI бага хурал угтаж ирэх жилийн хичээлийн бэлтгэл барилга засварын ажлаа богино хугацаанд амжилттай дуусгалаа.

Барилга засахад «Хэн уран барилгачин бэ?» гэсэн 14 хоногийн уралдаан зарлан 7 хоногоор дүгнэж байлаа. Барилга засвар дээр ажилласан Наваан ахлагчтай багш, ажилчдаас багш Баатармөнх, Бямбаа, Цэнд нар бусдаа-

саа илүү ажиллаж сургуулийн уран барилгачин боллогоов.

Дээрх багш, ажилчид 2 саяад засч 300 шоометр барилга шавардаж, шохойдож будан, 1000 гаруй төгрөгийн ажлыг сургуульдаа хийж өглөө.

Эдгээр багш, ажилчид сургуулийн дотуур байр, хичээлийн байр, анги танхимаа сэлбэн засварлах, будах, шохойдох, шиллэх зэрэг засварын ажлыг мөн дуусгажээ.

Л. НАРАНХҮҮ Ш.БЯМБАА



Аймгийн УААУГ-ын жолооч Ч. Хиравгаа аймгийн намын XVI бага хуралд төлөөлөгчөөр сонгогдон оролцож байна.

Тэрээр онгоцны хэв, усалгааны тэргэнцэр, шаврын циргүүд, тавиур зэрэг хэд хэдэн шинэ зүйл санаачлан хийж үйлдвэрлэлд нэвтрүүлсэн нь хөдөлмөр хөнгөвчилж үр ашгаа өгч байна.

ЗУРАГ ДЭЭР: Ч. Хиравгаа ажилд гарахын өмнө Л. ГУНГААБУУ-гийн авсан гэрэл зураг

МАЛЧ ТҮМНИЙХЭЭ МАНЛАЙД

1974 онд аймгийн хэмжээний төллөх бүх малын 10 гаруй хувийг намын гишүүд хариуцдаг. Тэдний хариуцан төлүүлж байгаа

бүх малын 90 гаруй хувь нь төлөж, гарсан төл нь бүрэн бойжиж байна. Эрдэнэсант сумын хоньчин, улсын аварга малчин Т. Ба- заррагчаа, хоньчин Н. Ба- дарч, Борнуурын САА-н Хүрлээ, Лүн сумын Дорж- сүрэн, Алтанбулаг сумын Пүрэвдорж нарын зэрэг 110 гаруй гишүүд 430-881 бог мал төлүүлж 18—70 ихэртэй, хүлээн авсан төл бүрийг сайн бойжуулж байна. Аймгийн хэмжээ- гээр мал төлүүлж байгаа бүх гишүүдийн 87,3 хувь 100 эхээс бойжуулах тө- лийн талаар МАХН-ын Төв Хорооны IX бүгд хур- лаас тавьсан зорилтыг

илүү бойжуулах бололцоо- той болоод байна.

Эрдэнэсант сумын «Са- руул-амьдрал» нэгдлийн хоньчин, улсын аварга мал- чин, намын гишүүн Т. Ба- заррагчаа энэ жил 609 мал төлүүлж 679 төл хү- лээн авч МАХН-ын Төв Хорооны IX бүгд хурлаас дэвшүүлсэн зорилтоос 104 төл илүү бойжуулжээ. Бор- нуурын САА-н хоньчин С. Хүрлээ энэ жил 871 хонь төлүүлж 915 төл хүдээн авч ганц ч төлийн гэрэ- гүй байна.

Намын гишүүн С. Хүр- лээ МАХН-ын Төв Хороо- ны IX бүгд хурлаас тавь- сан зорилтоос 76 төл илүү бойжуулж байна. Ийнхүү намын малчин гишүүд ай- мгийн намын XVI бага хур- лаа амжилтаар угтав.

Г. МЯГМАР

МОНГОЛЫН ХУВЬСГАЛЧДЫН ӨДӨР

1920 оны 6 дугаар са-рын 25-нд Монголын эрэл-хэг цогтой хувьсгалч нө-хөд нууц бүлгийн гишүү-дийн хамтарсан түүхт ху-рал болж хоёр бүлгийг нэгтгэж МАН хэмээх анх-ны хувьсгалч нэгдмэл байгууллагыг байгуулсан билээ.

Одоогоос 54 жилийн өм-нө үүссэн МАН хэмээх хувьсгалт байгууллага нь Орос оронд болж байсан хувьсгалт үйл явдлыг онц-гой анхаарч өөрсдийн эх-лэн явуулж байгаа хувьс-галт ажлыг октябрийн хувьсгалаар эхэлсэн дэл-хий дахины түүхэн үйл явдалтай холбож, Зөвлөлт орос ба коминтернээс тусламж туршлага авч ар-дын хувьсгалт хөдөлгөө-нийг зөвхөн үндэс угсаа-ны тусгаар тогтнолоо олох гэсэн явцуу хүрээнээс гэт-лэсэн гартах эрчимтэй хувьсгалт үйл явдлыг сө-

дөн санаачилж зохион бай-гуулжээ.

Монголын хувьсгалч-дын энэ үйл ажиллагаанд нийслэл хүрээнд ажиллаж байсан оросын хувьсгалт байгууллага, түүний идэвх-тэн гишүүд үнэлж барш-гүй их хувь нэмэр оруул-сан байна.

Тийм ч учраас нөхөр Я. В. Гембаржевский, М. И. Кучеренко, И. С. Мас-лаков, Кондииков нарыг Д. Сухбаатар манай намын итгэвээс зохих гишүүд гэж хувьсгалт байгуулла-гын гол гишүүдийн ади-лаар үзэж байсан байна.

Октябрийн хувьсгалын үзэл санаанд зоригжин боссон монголын ард тү-мний хувьсгалт баатарлаг тэмцлийн гал дунд манай эрэлхэг хувьсгалчдын үн-дэс суурийг нь тавьсан хувьсгалт нууц байгуул-лагаас эх авч үүссэн Мон-гол Ардын Хувьсгалт

Нам 53 жилийн яруу алдарт замыг туулахдаа В. И. Лениний сургаалыг удирдлага болгон эгнээн-дээ 50 гаруй мянган ком-мунистыг нэгтгэн бэхжиж чадаад социалист Монгол орныг удирдан жолоодож байгаа улс төрийн хүчир-хэг хүчин болсон байна.

Монголын хувьсгалчдын өдрийг жил бүр ёслол тэмдэглэж байхаар МАХ Н-ын Төв Хороо тогтоол гаргасан нь эх орныхоо тусгаар тогтнол, ард түм-ний зол жаргалын төлөө амь бие үл хайрлан тэм-цэгчдийн хувьсгалч баа-тарлаг үйлсийн жишээ-гээр манай орны хөдөл-мөрчид, залуу үеийг хү-мүүжүүлэн МАХН-ын про-граммыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Ийм учраас Монголын хувьсгалчдын өдрийг уг-таж тус аймгийн нам, улс, олон нийтийн байгуулла-

гаас октябрийн хувьсга-лын үр нөлөө, Монгол-Зөвлөлтийн ард түмний мөнхийн найрамдал, мон-голын ард түмний олсон ололт амжилт, залуу үеийг нам, ард түмний хувьсгалч дайчин уламжлалаар хү-мүүжүүлэх асуудлыг сур-талхлах, Лениний шүүдэг авах, чуулга уулзалт хийх зэрэг ажил зохиож цогт дайчин хувьсгалчдын жи-шээгээр сурч хөдөлмөр-лөх хөдөлгөөн өрнүүлж байна.

Монголын ард түмний эрх чөлөө тусгаар тогтно-лын төлөө чин зориг баа-тарлаг гавьяа байгуулсан Монгол—Зөвлөлтийн ах-мад хувьсгалчдын баатар-лаг үйлсийн жишээнээс суралцах, тэдний гэгээн дурсгалыг үргэлж хүндэт-гэн хайрлах үзлээр залуу үеийг хүмүүжүүлэхэд зүйл бүрийн дэмжлэг үзүүлэх, нэрт хувьсгалчдыг суд-лан сурвалжилж, мөнхжүү-лэн алдаршуулах явдал

Хувьсгалт тэмцлийн ах-мад зүтгэлтний зөвлөлийн гол зорилт мөн.

Монголын хувьсгалч-дын, өдрийг тэмдэглэж байгаа явдал нь ахмад хувьсгалчдаа дурсан хүн-дэтгэх төдий биш БНМА У-ын хөдөлмөрчид тэм-цэл ялалтынхаа туулж өн-гөрүүлсэн 53 жилийнхээ замыг зүй ёсоор бахархан яруу алдарт ардын хувьс-галын их ойг тэмдэглэх ажлын босгон дээр тулж ирээд байна.

Ийм учраас тус аймгий- нам, улс, аж ахуй, соёл гэгээрэл, олон нийтийн байгууллага, нийт хөдөл-мөрдөөс ардын хувьсга-лын яруу алдарт 53 жи-лийн ой, МАХН-ын III их хурал, БНМАУ-ыг тун-хагласны 50 жилийн ойг угтаж аж ахуй, соёлын төлөвлөгөөт зорилтыг ху-гацааны нь өмнө бүрэн биелүүлэхийн төлөө бүх хүчээ дайчлан ажилла-цай!

Г. ШАРАВ

1
Ялалтынхаа сүрийг, ололтынхоо бярыг ямагт бид намтайгаа холбон үздэг билээ. Монголын ард түмэн МАХН-ынхаа заасан замаар явж аугаа их хөгжил дэвшил хүрлээ. Намын зүрх сэтгэл нь жирийн хүн болохоор нандин үйлс бүхэн нь сэтгэлчлэн бүтдэг. Манай нам ялагдашгүй цул нэгдэлтэй, гийсэн мэргэн ухаантай, дийлэгдэшгүй хүчин чадалтай билээ. Манай хамаг гайхамшиг бүхэн намын бодлого биелэлээ олсны баталгаа юм.

Эх орныхоо ирээдүйн төлөө намын мэргэн хараа тусгайг тэмцэл хөдөлмөрийн талбар гэж байхгүй. Тэмцэл хөдөлмөрийн хамгийн хэцүү хүнд цэгт намын хүн намын даалгавар биелүүлж, нийтийн үйлсийн төлөө алтан амиа хайрлаагүй алдар гавьяаны гэрэлт мөрүүд тодхон байна. Намын хүн эх орон, элбэрэлт түмнээ зүрхэндээ багтааж явдагийн учир, эв хамтаад зорьсон их тэмүүлэлээр нь амьдардгийн учир тийнхүү бүхний магнийд явдаг.

Эдүүгээгийн жаргалыг авчрах гэж түүхийн харанхуй шөнөөр «Магнаг үсэгтэй тугаа магнай дээрээ мандуулж» дайсны өөдөөс уухайлан орж эх орноо гэсэн халуун сэтгэлийнхээ хатаар дайснаа дарж аз жаргал эрх чөлөөг авчирсан тэр партизанууд намын хүн байлаа.

Найран дээр дуулсан дуу гэнэт тасарч Наадамд уралдсан морьд дутуу эргэж Төвшин энх түмэн ард минь

Түйвээний чимээг түгшин сонсоход намын хүн хамгийн түрүү галын тэргүүн шугаманд гарч эх нутгийнхаа сөөм газарт ч харьтны хөл гишгүүлэхгүйн тө-

2
лөө бүргэдийн зоригоор баатарлаж явлаа.

Цэлмэг залуу насны гал дөлөөр бадарч Сэтгэлзүрх хоёртоо шатаж явах үедээ Чин сайхан амрагтаа хэлж үзээгүйгээ Чиний төлөө үхье гэж эх орондоо хэлж атаатны сумыг зүрхээрээ хаасан тэр Аюушчууд намын хүн байлаа.

Тэмцэл ялалт, хөгжил бадралынхаа гэсэн сүрийг НҮБ-ын тэнгэрт тугтайгаа хамт өргөсөн төрийн зүтгэлтэн намын хүн байлаа. Уурхайн гүнд тачигнах ган өрмийн чичиргээн дунд ухаан бяараа бүтээлийн хүдэр ундруулсан ууган

НАМЫН ХҮН

(Нийтлэл)

баатар Даваажав шиг тэр хүмүүс намын хүн.

Ай түмэн сүргээ хариулж явахдаа мал маллахын эрдмийг шинжлэх ухаанд нэмэрлэж профессор хоньчин гэдэг эрхэм алдар хүртсэн Очир гуай шиг тэр хүмүүс намын хүн юм.

Гэгээн Зөвлөлт орны

Найртай сайхан тусыг

Нэгэн хүүтэй эхийн

Хайртай зүйрлэн сэтгэлийг ямагт өндөрт өргөж, найрамдал эрх чөлөөний паранд элч гэрлээ нэмж өргөн дэлхийн хаана ч гэсэн өгөөмөр тусч сэтгэл нь хүрч байгаа тэр хүмүүс намын хүмүүс юм. Иймч учраас намын хүн дэлхийн 50 сая коммунистуудтай нэгэн зүрх сэтгэ-

3
лийн тэмүүлэл, тэмцлээр доглож явдаг. Чиглэсэн зорилгынхоо бэлчирээс буцалгүй ач тусгаа ард түмэндээ зориулсан намын хүмүүсийн ухаан бар, уран гар, цаг үеийн оргилыг давуулж ирээдүйнхэндээ хөгжлийн цэцэг тарьж байна. Хувьтай энэ орондоо хувьсгалт улсаа мандуулж, хойчийн шинэ ертөнц дээр хүндтэй гавьяа байгуулж гэсэн чин сэтгэлийнхээ дуудлагаар намдаа элсээд намын батлах, намаас өгсөн итгэл найдвараар намын хүн бахархаж явдаг. Намын үйл хэрэг бол эх орон, энх тайван, коммунизм билээ.

Үхлийн шарх биеийг шаналаавч Үлэмжийн ариун батлахаа хараад Олон коммунист дахин боссонд Оволзсон тэмдгийн жилүүд мартаагүй. Намын итгэлийг намын хүн хадгалж коммунизм дэвшинэ.

Энэхүү итгэлийн жигүүр эрдэмтний ухааныг шинэ нээлтэд хүргэж, инженерийн оюунд хот амилуулж, ажилчны хүчирхэг гараар үйлдвэрийн суурь машин нүргүүлж, эх орныхоо цээжинд аварга хөгжлийн дуулга өмсөж байна.

Намын хүлээлгэсэн итгэл чухам л доктор Шагдарсүрэнгийн уран гарч мээ засалчийн алтан хутга барилж хүний амьдралын «мотор» их засвар хийлгэдэг. Намын хүнд намын үйл хэргийн төлөө гэсэн «тангараг» хүчит луужин нь болж ямагт түүгээрээ чигээ барьж үүсгэсэн үйлсийнхээ төлөө ган болд мэт шантрашгүй явж бэрх бүхнийг ялан давдаг учиртай.

Б. ЦЭРЭНДАШ

Ш. ЦЭРЭНДОО

ҮЗЭЛ СУРТЛЫН АЖЛЫН ҮР НӨЛӨӨ

Аймгийн Намын XV бага хурлаас хойших хугацаанд МАХН-ын XVI их хурал, Төв Хорооны удаа дараагийн бүгд хурлууд, тэргүүний суртал нэвтрүүлэгч, ухуулагчдын болон намын АШБ-ын нарийн бичгийн дарга нарын улсын зөвлөлдөөнөөс дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэх талаар ихээхэн ажлууд зохиогдоо. Энэ хугацаанд намын улс төрийн сургууль, малчин гишүүдийн улирлын сургуулийг МАХН-ын Төв Хорооны шийдвэрээр шинэчлэсэн системийн дагуу зохион байгуулаа. Өнгөрсөн 3 жилд намын улс төрийн анхан шатны сургуулиас дунд, дээд шатанд дэвшин суралдагчдын тоо 46,3 хувиар, нийт суртал нэвтрүүлэгчдийн дотор дээд боловсролтой суртал нэвтрүүлэгчдийн эзлэх хувийн жин 10 хувиар өсч, Хөдөлмөрчдийн дунд суртал ухуулгын ажлыг зохион байгуулагч гол хүч болсон ухуулагчдын бүрэлдэхүүнд чанарын өөрчлөлт гарч, суртал ухуулгын ажлын хэмжээ далайц өсч, арга хэлбэр нь улам боловсронгуй болсоор байна. XV бага хурлаас хойших хугацаанд нийт ухуулагчдын дотор намын

гишүүдийн эзлэх хувь 56,4—59,2 болж дээд дунд боловсролтой ухуулагчдын тоо 39,9—57,3 хувиар өсч, Энэ завсар БНМАУ-ын хөдөлмөрийн баатар аймгийн аварга сайчууд 19 хүнийг мэргэжлийн ухуулагчдаар, удирдах ажилтан мэргэжлийн сэхээтэн 400 гаруй хүнийг улс төрийн мэдээлэгчээр батлан ажиллуулав. Хөдөлмөрийн хөдөлмөрчдийн дунд зохиох соёл хүмүүжлийн ажлын чухал хэлбэр болсон бригад, фермийн өдөрлөг тогтмолжин үр нөлөө нь дээшлэв. Өнгөрсөн оноос эхлэн суурийн хүмүүжлийн ажил шинэ системийн дагуу явагдаж малчид, тариаланчдад эдийн засаг, эрх, мал аж ахуйн арга ажиллагаа технологийг системтэй судлуулж байна. 1973 онд БНМАУ-ын хөдөлмөрийн баатар Б.Ажваагийн бэлчээрээр мал таргалуулдаг арга ажиллагааг нийт малчдад судлуулсан явдал ихээхэн үр дүн өглөө.

1971 онд аймгийн хэмжээгээр 586 мянган төгрөгийн хэвлэл захиалж байсан бол энэ онд бараг 700 мянган төгрөгт хүрч дунджаар 1 өрхөд оногдох хэвлэлийн төрөл 2,2 байснаа 4 болж, радио цэ-

гийн тоо 9 хувиар, зурагт радиогийн тоо бараг 3 дахин өсч, Гурван жилд киноны гаргалт 9,5 хувиар, номын сангийн номын фонд 20 гаруй мянган ботиор нэмэгдэж соёлын байгууллагуудын тоо, үйлчилгээний хүрээ, материаллаг бааз нь өргөжлөө. Энэ хугацаанд ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын тоо 1,7 мянгаар өсч хөдөлмөрчдийн ерөнхий боловсролын түр болон улирлын сургууль төгсгөдлийн тоо 70 гаруй хувиар өсчээ.

Хөдөлмөрчдийг эмнэлгээр үйлчлэх ажлын хүрээ өсч 1000 хүнд оногдох хүн амын цэвэр өсөлт энэ завсар 28—31 болон нэмэгдлээ. Хөдөлмөрчдийн худалдан авах чадвар аж амьдрал соёлын хэмжээ дэвшилж, нийт бараа гүйлгээ 10 гаруй хувиар өсөв. Аймгийн намын XV бага хурлаас хойших хугацаанд тус аймгийн хөдөлмөрчид, ардын хувьсгалын 50 жил, ЗСБНХУ байгуулагдсаны 50 жил, төрөлх аймгийнхаа хагас зууны түүхт ойнудыг хөдөлмөрийн бахдам амжилтаар тэмдэглэж байсан намын XVI бага хурлаас хөдөлмөр соёлын их өрнөлтөөр угтав.

Я. ДАМДИНСҮРЭН

ТАВАН ЖИЛИЙН ГАВШГАЙЧИД

Манай эх орны хөгжилд томхон алхаа болох V таван жилийн төлөвлөгөөг хугацаанаас нь өмнө давуулан биелүүлэгчдийн эгнээ тус ямагт тэлсээр байна. Аймгийн хэмжээгээр V таван жилийн төлөвлөгөөг давуулан биелүүлэгчид одоогийн байдлаар 90 шахам төрж тэдний тоо улам нэмэгдсээр байна. Таван жилийн гавшгайчдын дотроос БНМАУ-ын хөдөлмөрийн баатар, МАХН-ын гишүүн, Угтаалын САА-н тракторч комбайнч Г. Алтанхүү 3 жилд СК—4 комбайнаар 3293 тонн үр тариа хураах авч 11 жил 7 арван ажил гүйцэтгээд түрүү магнай нь явна. Түүний араас Батсүмбэрийн САА-н ногоогч, БНМАУ-ын 3 удаагийн аварга ногоогч чин, МАХН-ын гишүүн Ж. Баатар, хөдөлмөрийн баатар Я. Должинжав, Угтаалын САА-н трактор-комбайнч Л. Нэргүй, Жаргалантын САА-н тракторч, БНМАУ-ын хөдөлмөрийн баатар Ч. Дугарсүрэн, М. Чойжамц, Эрдэнэсант сум—нэгдлийн хоньчин, БНМАУ-ын аварга малчин П. Базаррагчаа, Мөнгөнморьт сум—нэгдлийн саалчин, Ардын Их Хурлын депутат А. Ичинхорлоо, Алтанбулаг сум нэгдлийн сааль-

чин, аймгийн депутат Д. Чинбат, хөдөө нутгийн «Гүнжилам» болсон, БНМАУ-ын аварга малчин Батсүмбэрийн САА-н саальчин Ц. Хорлоо, XIII авто баазын жолооч О. Шагдар, Зам ашиглалтын ангийн жолооч Т. Самжаан, НААҮГ-ын өбдөлдчин Дашхермаа, Цэгмид, эсгүүрчин Дарьсүрэн, төмөрчин Банзрагч, Борнуурын САА-н кино-механик Доолоо, Мөнгөнмортын Базаргүр нарын зэрэг хүмүүс 5—8 жил илүүгийн ажил гүйцэтгээд улам их бүтээлийн төлөө уралдаж байна.

Батсүмбэрийн САА-н Ж. Пүрвээ даргатай, БНМАУ-ын аварга бригад хамт олноороо 3 жилд 5 жил 2 сарын ажил гүйцэтгээд социалист уралдаанд нэмэлт үүрэг аван улам давуу амжилт гаргахаар идэвхийлэн ажиллаж байна. МАХН-ын гишүүн Г. Лувсанчултэм даргатай социалист хөдөлмөрийн Зам ашиглалтын ангийн хамт олон 5 жилийн төлөвлөгөөг хугацаанаас нь 2 жил шахамын өмнө ханган биелүүлэв.

Эд цөм V таван жилийн гавшгайчид, манай үеийн бахархан дуурих үйлстнүүд билээ.

М. САМДАН

ТРАКТОРЧИН БОЛНО

Өндөрширээт сумын дунд сургуулийн 7 дугаар ангийг энэ хичээлийн жилд төгссөн сурагч Ганхуяргтай уулзаж ярилцвал: Би саяхан 7 дугаар анги төгсөлөө. Одоо эвэллийн ил-

гээлт өвөрлөн тариа бригад дээрээ очиж ах Болд шигээ аварга тракторчин болно гэж баяр хөөртэй өгүүлэв.

Д. ЮМСҮРЭН



*Зуунмод хотын худалдаа бэлтгэлийн трестийн Их дэлгүүрийн Долгор ахлагчтай 1 дүгээр заалын хамт олон, хүүхдийн хувцасны худалдагч Баттө-

мөр, соёлын барааны худалдагч Бүрнээ, халуун усны мухлагийн худалдагч Цэрэнжав нар аймгийн намын XVI бага хурал угтаж 1974 оны эхний хагас жилийн төлөвлөгөөгөө 100—113,2 хувиар биелүүлж сайхан амжилт гаргав.

Г. ГАЛЯ

*Аймгийн XIII авто баа-

С. ОТГОН

Яргуй хөөсөн ямаан сүрэг: салхи сөрөг хушуурч шовор шовор алхална.

Ямаачин Лхам сүргийнхээ түрүүнийг чимээ өгөн тогтоогоод шимтэн уншиж байсан шинэхэн романаа ширтэн тогтоод.

Нялх ногооны шимийг хангалтаа хүртсэн ямаан сүргийн гишүүдэд мэдэгдэхүйц удааширч, Гэрэлтийн уужим хөндийг элжин хүрээлсэн сүрэг уулын урд захаар орших тогтоодог өнгөрлөн өгсөж хярдан тогтжээ.

Ямаачин Лхам хэдийгээр нас залуу, цус шингэн боловч, нэгэнт зуун чаагаан ажил эрхлэдэг байсан бяцхан үеэсээ эхлэн малчин хүний намба сууж, хуучин хүний төрх тогтоолоо малын бэлчээр дэвж, малчны сурвалж сонсон тул туршлагаар малчны эхнээнд хэдийгээр оржээ. Тэрээр олон сайчуудын туршлагыг радиогоор сонсож, сонин хэвлэлээс уншиж, дэгл хөдөлмөрийн амжиг бүрэн авсан өгөн буурал малчдынхаа эхнээ шавар элсэж, үе дамжсан алдарт малчин болохоор амлаж зориглон шийд-

сэн эгдэл жирийн нэгэн ямаачин юм.

Эндонгийн Лхам анх 1959 онд хоньчин гэдэг сайхан ажил хийж эхлэв.

Чухамхуу тэр үед бага сургуулийг дөнгөж дуургээд малчин болсон 12-13 настай бяцхан охин байсан учраас ёстой л гарын үзүүрт годонож, хүний аяар бонжигнож явсан нь мэдээж. Гэвч төрөлхийн өвсөг найрсаг, багын ажигч гярай тэр охин, ахын сургаалыг алт, ажлын ам-тыг хужир гэж амтархан

Б. ТОГООХУУ

ӨВГӨН МАЛЧНЫ ЭЧНЭЭ ШАВЬ

НАЙРУУЛАЛ

сонсож, хэрэгжүүлэн биелүүлж сурсан нь түүнийг амжилтанд хүргэж туршлагатай ямаачны эхнээнд оруулсан байна.

Хоньчин Лхам 1968 оноос эхлэн ямаачин болохоор шийдэжээ.

Ямаан сүрэг хариулах Ягуй ажил гэдэг л.

Ажилд залуу зарим хүн Ад үздэг гэнэ лээ шүү гэсэн дуу байдаг. Үгэндээ ч

ямаан сүрэг хариулах гэдэг ягуй ажлын нэг. Гэвч жинхэнэ хөдөлмөрч малчин хүн гэдэг ажил хөдөлмөрийг хүнд хөнгөн гэж ялгаагүйн дээр, ер нь хүнд хэцүү гэснийг л хийхийг голчилдог ажээ.

Ямаачин Е.Лхам МАХН-ын гишүүн хүн. Тийм ч учраас хуулийн хүнд хэцүү гэж үздэг. Ямаачны мөргөжлийг сонгон авчээ.

Яг асаран цэнхэртэх ямаан сүрэг яргуйн сор хөөр шовор шовор алхана. Тэрээр Улхын булан, Та-

жээ, Гэтэл анх хочилж гарсан өнө нэр одоо байрхлын үг болжээ.

Үгэндээ ямаачин Лхам бол багштай ч хүн, шавьтай ч хүн. Тийм ч учраас ажил нь өөдрөг, үйлс нь бүтэмжтэй явдаг юм.

Лхам хүүхэн тогтуун адшилж явсан ямаан сүрэг нэг бүрчлэн харснаа сүгз 11 дөхөж байгаа шүү! Сүүлийн үеийн мэдээ сонсч байх гэж бодоод барьж явсан хүлээн авагчид нээв. Радиогоор: Мөөлөн хоёр молцогтой

лан бахархалын шинж бүрэн илэрч

—Хонь ямааг хамт маллахад нэг л онц биш юм даа. Ямаа нь бэлчээрээ голоод явдал нь тургэдээр тун хэцүү байдагсан.

Дангаар нь сурилж, саанаанд нь таарсан бэлчээрт байлааг байвал ч тийм яргштай, маллахад хэцүү ч мал биш л юм даа. Ямаа... гэж сонин амьтан шүү! Хамгийн амттай ургамал, ялангуяа навч цэцэг идэх тургайгүй нь ямаа, тийм ургамал харахаараа бүр тогтож өгөхгүй шүү, бүр яараад, шогмоод очно гэдэг. Тарахуу бурэн аваад ирэхээр ч андшиггүй л дээ.

Хууу нь бүдүүрч үс нь шигүүрээд л нэг л ондоо доо. Маш бээрэг мал учраас хамгийн дулааг хашаа хороо, хүрэл цэхүйц хэмжээний тэжээлийн нөөц л хуйтний улиралд чухал даа гэж бодож суу. Тэрүүний ямаачин Е. Лхам аймгийн намын XVI бага хурлын төлөөлөгчөөр Баян-Өмжүүл сумнаас сонгогдон ирээд байна.

Анхны бодол

Самплын Банзрагч 1972 оны хаврын нэгэн өдөр уулын ар өврөөр тэр арваараа тархихсан он адууг харж суухдаа, Зарим адуучин яахлаараа хоньт нэг удаа эргэж төдийгөөр адуу малладаг байна даа. Гүү унагалж, хөөвөр хялгас хаягдаж хаврын гэнэн шуурга гээд л чухам адуучин нойрыг хулжаадаг үе биш билүү. Ингэж маллахаар адууны осол эндэгдэлдүргэлжилж төлөвлөгөөний тасалдлаас наж ангирах билээ дээ. Аяга, Шанага, Аргал, Сэрүүний нуруу гэдэг ёстой л эзэн хичээвэл түшээд өгдөг нутагдаа. Би ер нь адуучин болъё гэвэл намын үүр, нэгдлийн зөвлөл хүлээж авах болов уу.

Амжилт гаргаж болох ажил шүү гэж бодсоор мордлоо.

Ажлын эхлэл

1973 оны хавар Банзрагч адуугаа азарга азаргаар нь бүртгэж азарга түүний нас, бие онцлог нэг азарганд оногдож бай-

АДУУЧИН

М. И. Д. 1973. 13. 1

гаа гүү, азарга тавьчихмаар үрээ, гүүний хээл зэргийг судалж явав.

Миний авсан 500 адуунд 195 гүү байна. Гэтэл дөнгөж 40 гаруйхан гүү хээлгүй юм. Зуун гүүнээс дөнгөж 27 хувиар унага авах нь дээ гэж бодоод гүү хээлтүүлгийн зохион байгуулалтын шинэ арга хэмжээ авах арга эрэлхийлэв. Юуны урьд гүү, азарганы тохироог хийж, азарган үрээг эрт заслаа.

Гэр бүлээрээ нутгийг сонгон нүүх замаар гүүгээ саан, адууг өдөрт нь сувайлж азаргыг зэл сахиулахгүй болгодоо.

Гүүгээ азарга азаргаар нь ээлж хийх замаар хээлтүүлэг явуулж, өвөл хавар гүүний хээл хамгаалах малчин хүний хийх бүхнийг яв цав гүйцэтгэв.

Ажлын үр дүн Энэ онд адуучин Банз-

рагч гүүнийхээ 82 хувийг хээл авахуулж, хээл хаялтыг 100 хувь, сувайралтыг 59 хувиар тус тус багасгаж чаджээ. С. Банзрагч илгээлтийн эзэн Гончигжавыг дагуулан ажиллаж, туслах адуучин Пүрэвжавтай ээлжлэн адуугаа хоньчлон хариулж, шөнийн манааг тогтмол болгосон байна. Байсан ба хөгшин гүүний унагыг онцлон анхаарч арчлах, унагыг гармагч нь бүртгэн авах, адууг усанд ороход урд нь орж тогтоох зэрэг замаар ажилладаг байна. Социалист уралдаанд 100 эхээс 85 унага бойжуулах үүрэг авснаа биелүүлж 125 гүүг 82 хувийг хээл авч, 125 унага бойжуулж аваад байна.

—Аав адуучин хүн байсан болохоор адуу маллах арга зүйг бага боловч мэднэ. Миний өчүүхэн амжилтыг өндрөөр үнэлж Алтанбулаг сумын намын хамт олон намайг аймгийн намын XVI бага хуралд төлөөлөгчөөр сонгосон явдалд маш их баярлаж байна гэж Банзрагч ярилаа.

Ш. ДИНАМ

ТЭРГҮҮН ТУРШЛАГА АМЖИЛТЫН ҮНДЭС

Тус аймгийн намын байгууллагууд ЗХУКН болон орон нутгийн намын байгууллага, тэргүүний хүмүүсийн туршлагыг эзэмших ажил зохиож байгаа нь үр дүн өгч байна.

ЗХУКН-ын туршлагаар хөдөлмөрийн баатруудыг зөвлөх багшаар ажиллуулахын зэрэгцээ тэдний нэрэмжит шагналыг 46 хүн авсан байна.

Хөдөлмөрийн сайчуудыг сурталчилдаг Зөвлөлтийн туршлагаар 38 хүний сууцанд хаяг хадаж, хөдөлмөр алдрын 5 хушуу, 82 хүний зургийг эзэмшсэн техникт нь зурж, 1000 орчим хүний ар гэрт нь талархлын хуудас, багцын цахилгаан, захидал илгээв. ЗХУ-ын Саратов мужийн намын байгууллагын туршлагаар хүн бүрээр жилийн эхэнд болон цаг үеийн чухал кампанит ажлын үеэр үүргэмлэлт авахуулж түүнийг үйлдвэрлэлийн даалгаврын биелэлтийн хамт цуваагаар байр эзлүүлэн дүгнэдэг явдал заншил боллоо. Үүний үр дүнд 3 жилд 5-аас дээш жилийн ажил хийсэн байгууллага, хувь хүний тоо олширов. Баянцогт, Бөрнуурын САА-нууд, Завхан аймгийн Цэцэн уул, Ховд, Говьалтай аймгуудын намын

байгууллагуудын туршлагаар бог малын сүүг фермийн аргаар ашиглах, мал оторлох, хоньны суурийн малчдын ар гэрийг өргөн айлсалтаар зохион байгуулж ажилласан нь үр дүнд хүрлээ.

Малын өвөлжилт, төл хүлээн авалт, хадлан тарианы бэлтгэл ажлыг намын гишүүдээр урьдчилан хангуулж хүлээн авдаг Ховд аймгийн намын байгууллагын туршлагаар ажилласны дүнд Жаргалантын САА-н хоньчин П. Уртнасан эм хонь бүрийг дундаар 74 кг, ноосыг 815 граммд хүргэж аймгийн аварга болсон юм.

Угтаалын САА хөдөлмөрийн баатар Г. Алтанхүүгийн нэрэмжит уран хадгалтын уралдаан зохиож 60 комбайнчин тариа хураалтын 2 хоногт 4500 га талбайн ургац хурааж 8 комбайны 2 өдөрт гүйцэтгэх ажлыг илүү хийжээ.

Мөн хөдөлмөрийн баатар Б. Ажваа, Г. Алтанхүү, улсын аварга Н. Болд Х. Очирбат нарын олон сайчуудын ажлын туршлагыг 421 хүн эзэмшжээр ажиллаж 362 хүн эзэмшээд байгаагийн 105 нь туршлага эзэмшсэн гэрчилгээ авлаа.

Ц. МАЖИГСҮРЭН


ЗӨВЛӨЛГӨӨН БОЛОВ

Саяхан аймгийн ҮЭ-ийн Зөвлөл, ЦС Ангаас эрхлэн аймгийн төвийн үйлдвэр аж ахуйн газруудыг аж ахуйн эрхлэгч, дежур, манаач, сахиуларын зөвлөдгөөн хийлгэв.

Зөвлөдгөөнд ЦС Ан-

гийн ажилтан Ю. Нэргүй «Манаач, дежур, сахиулагч хариуцагчдын сонор сэрэмж ажлын хариуцлагыг сайжруулах» гэсэн сонсгол тавьж хэлэлцүүлэв.

Д. БАДАРЧ



Алтанбулаг сумын "Хөдөлмөр" нэгдлийн Алтанбулаг бригадын адуучин, МАХН-ын гишүүн С. Банзрагч өөрийн саналаар адуучин болсон анхныхаа жилд 125 гүүнээс 125 унага бүрэн манд бойжуулаад байна. ЗУРАГ ДЭЭР: Адуучин С. Банзрагч

Д. ТОВУУ-гийн авсан гэрэл зураг.

ХАРИУЦЛАГАТАЙ ЭРХЛЭГЧ

Д. ТОВУУ